



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2022 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ  
БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</b>							
/“Алсын хараа-2050” зорилт 5.3, 7.4, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, 7.4, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Аймгийн “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.1/							
<b>Зорилт1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</b>							
1.1	Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв 2.000,0 сая.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	-Төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжсэн байна.	Хэлтсийн архив, ажлын байрны төсөв улсын төсөвт суусан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотой төсөв буцаагдсан болно. Энэ хүрээнд аймагт баригдаж буй төрийн байгууллагуудын цогцолбор барилгад тус хэлтэс орох саналаа өгч шийдвэрлүүлсэн, шинээр баригдсан төрийн байгууллагуудын цогцолбор барилгад орох бэлтгэл ажиллаа хангаж байгаа болно.	100%
1.2	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	Улсын төсөв 5.800,0 сая.төг	-Тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлыг хангасан эсэх;  -Сургалтад	-Тоон гарын үсгийн тухай хууль батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэн.  --Тоон гарын үсгийг	Иргэдэд тоон гарын үсэг олгогдсон байна.	Бэлтгэл ажлыг бүрэн хангаж, Иргэний тасгийн ахлах болон мэдээллийн технологийн ажилтан нар УБЕГ-аас зохион байгуулсан тоон гарын үсэг олгох талаарх сургалтад 2022 оны 04 сард	100%

			хамрагдсан албан хаагчдын тоо;  -Иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо.	улсын бүртгэлийн байгууллагаас олгохтой холбоотой Тоон гарын үсгийн тухай хууль, түүнийг дагалдан гарах хуулийн төсөл, одоогийн дагаж мөрдөж байгаа хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.		хамрагдсан болно. 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 18838 гаруй иргэнд тоон гарын үсэг олгоод байгаа ба аймгийн хэмжээнд байгаа 16 дээш настай нийт иргэдийн 30 гаруй хувьд олгогдоод байна. Мөн 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн МТГ-аас авсан зөөврийн тоног төхөөрөмжөөр аймгийн төвийн сургууль цэцэрлэг, аж ахуй нэгж, албан байгууллагуудад хуваарь гарган төвийн бүртгэгч нарыг ээлжээр ажиллуулан тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлж ажиллав.	
1.3	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх.	-	Өгөгдсөн чиглэлийн дагуу хэрэглээнд нэвтрүүлэх		-Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.	Иргэний бүртгэлийн дугаарыг 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хэрэглээнд нэвтрүүлэн олгож, хэвлэгдэн гарсан төрөлтийн 363, гэрлэлтийн 93, нас баралтын 60 бүртгэлийн гэрчилгээнд олгогдсон болно.	100%
1.4	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах		Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо;	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	-Шинэ дэвшилтэд технологийг ашиглан бүртгэлийн чанарыг сайжруулж, бүртгэл хөтлөх	Сүлжээний тоног, төхөөрөмж эвдрэл, гэмтэл гарсан үед тухай бүр завсар үйлчилгээ хийж, нэгдсэн сүлжээ мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. КОЙКА төслөөр хэлтсийн төвийн нэгдсэн сүлжээг дамжуулж буй SOPHOS шинэ роутерийг шинэчлэн тавьсан. Ингэснээр системийн хэвийн ажиллагаа аюулгүй байдал сайжирсан. Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчдын компьютерт давхардсан тоогоор <b>85</b> удаагийн үйлчилгээ хийж доголдлын арилгаж, шинээр гарсан тоон гарын үсэг олгох, гадаад паспорт зураг засах, илгээх зэрэг программ хангамж,	100%

						системүүдийг тухай бүр нэвтрүүлэн ажиллаж байна. 2022 онд тус аймгийн 5 суманд ЭХЭУБ-ийн ерэг системийг нэвтрүүлэн ЭХЭУБ-ийн үйлчилгээг тухайн сумаас үзүүлж байна.	
1.5	Архивын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах		-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо;  - Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	21 аймагт болсон бүсчилсэн сургалтанд оролцож, сургалт, мэдээлэл хүргэсэн.  Төрийн архивын улсын үзлэгийг дүгнэх аргачлалын дагуу гүйцэтгэлийн биелэлтийг авч дүгнэсэн.	Архивын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдсан байна.	Хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн 1978-2000 он хүртэлх ХААТР-1, 11 маягтуудад сэлбэн ажиллах, байршуулах /28 хайрцаг 20340 маягт/ ажлыг сумдын улсын бүртгэгч нарыг ажиллуулан 100% хийж гүйцэтгэв. Хэлтсийн БНШАЗК-ийн шийдвэрээр устгах жагсаалтад орсон баримт бичгийг эхний улиралд багтаан нийт 5344 ширхэг ХААТР-21 маягт, 346 ширхэг хадгаламж нэгж болон бүртгэлийн дэвтэр 74 ширхэг нийт 181,650 гаруй хуудас бүхий материалыг тус тус устгалд оруулсан болно. Мөн УБЕГ-аар 2022.04.29-ны өдрийн 6/3763 тоот чиглэлийн дагуу архивын хувийн хэрэгт байгаа нотлох баримтуудыг ангилан ялгаж, үүргийн гүйцэтгэл нь хангагдсан барьцааны гэрээ, зарим төрлийн лавлагаа зэрэг нотлох баримтуудыг цахимжуулахгүйгээр тусгаарласан хуудаснуудыг нэг бүрчлэн хянан шалгаж, нийт 188750 хуудас буюу 755 нэгж үүсгэн устгал хийлээ. 2023 онд устгалд оруулах жагсаалтыг гаргаж хүргүүлсэн. Мөн шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 916 бүртгэлийн бүрдүүлбэр бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлэн ажиллав.	100%
1.6	Улсын бүртгэлийн байгууллагын бодлого шийдвэр, цахим үйлчилгээг		-Сурталчилсан мэдээ мэдээллийн тоо.	-	-Бодлого шийдвэр, цахим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд	Улсын бүртгэлийн бодлого шийдвэр, цахим үйлчилгээг сурталчилах ажлыг тогтмол хийж ажиллаж байна. Тайлант хугацаанд иргэн, эд хөрөнгө,	100%

	сурталчилан ажиллах				сурталчилан ажилласан байна.	хуулийн этгээдийн улсын бүртгэл, бүртгэлийн үйл ажиллагааг тус хэлтсийн <a href="https://bayan-ulgii.burtgel.gov.mn/">https://bayan-ulgii.burtgel.gov.mn/</a> цахим хуудсанд <b>124</b> мэдээлэл, нийгмийн сүлжээний <a href="https://www.facebook.com/bayanulgii.burtgel">https://www.facebook.com/bayanulgii.burtgel</a> фэйсбук пэйж хуудсаар <b>181</b> мэдээллийг олон нийтэд түгээж сурталчлан ажилласан байна.	
1.7	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх	-	<p>-Иргэний улсын бүртгэл хөтөлсөн тоо;</p> <p>-Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн тоо;</p> <p>-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн тоо.</p>	<p>2021 онд ИУБ-ийн чиглэлээр 23695,</p> <p>Хуулийн этгээдийн чиглэлээр 740 бүртгэл тус тус хийгдсэн байна.</p> <p>Нийтдээ 13253 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэснээс газар өмчлөх эрхийн бүртгэл 4669, газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 1866, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 6718 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.</p>	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	<p>Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, 12 сарын 01-ны өдрийн байдлаар 27337 иргэн хамрагдсан байна.</p> <p>Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 7872 бүртгэл хөтөлсөн ба газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 2087, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл 4143 тус тус бүртгэл хөтөлсөн байна.</p> <p>Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 996 бүртгэл бүртгэсэн.</p>	100%
1.8	Тамга, тэмдэг хэрэглэх эрх бүхий этгээдээс хураалгасан тамга, тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах	-	2021 онд төрийн архивт тамга, тэмдэг шилжүүлээгүй ба нийт 65 тамга, тэмдгийг хэлтсийн даргын	УБЕГ-ын даргын тушаалаар 1 индекс, 1 код батлагдсан.	Хуулийн этгээдийн хэлбэрийн индексийг батлуулж, мөрдсөн байна.	Тайлант хугацаанд эхний хагас жилд хураагдсан 42 тамга, тэмдгийг албан тоот, жагсаалтаар аймгийн Архивын тасагт шилжүүлэн өгч ажиллав. Өнөөдрийн байдлаар хураагдаад байгаа 13 тамга, тэмдгийг 12 дугаар сарын сүүлээр шилжүүлэн ажиллах болно.	100%

			тушаалар томилогдсон ажлын хэсэг устгалд оруулсан байна.				
<b>Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.</b>							
2.1	Е-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хэлтэс, сумдаас үзүүлэх	-	Цахим хэлбэрээр үзүүлсэн тоо  Үйлчилгээний төрөл	Цахимаар захиалсан гадаад паспорт 30, иргэний цахим үнэмлэх 238 ширхэг олгосон	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал Е-mongolia-аар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн байна.	Эхний 11 сарын байдлаар <a href="http://www.e-mongolia.mn">www.e-mongolia.mn</a> веб сайтаар захиалан гадаад паспорт 36, иргэний цахим үнэмлэх 175 ширхэг хэвлэгдэн ирсэн ба тухай бүр иргэдэд олгосон болно. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр оноосон нэр, цахим гэрчилгээ баталгаажуулах 971 хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн болно. Мөн өнөөдрийн байдлаар Е-Монголиаар шилжилт хөдөлгөөний бүртгэлээр 4 иргэн захиалга өгсөн ба холбогдох нолох баримтуудыг хавсаргаагүй тул татгалзаж хариу өгч ажиллав.	100%
2.2	Иргэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд дундын мэдээллийн сан ашиглах	-	-Дундын мэдээллийн сангаар дамжуулан олгосон эрхийн улсын бүртгэлийн тоо	ЭМЯ-ны төрөлтийн мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан авч, 3000 регистрийн дугаар, ГЗБГЗЗГ-д 1866 Е-дугаар цахимаар олгосон.	-Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаар дамжуулан олгосон байна.  -Шинээр төрсөн хүүхдэд дундын мэдээллийн сангаар дамжуулан регистрийн дугаарыг олгосон	Иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор газар эзэмших, ашиглах /"Э", "А"/ дугаарын автоматаар олгогдсон <b>3127</b> дугаарын газар эзэмших, ашиглах эрхтэй холбоотой мэдээллийн хуудсыг системээс хэвлэн дугаарын дарааллын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгч ажиллаж байна.  Эрүүл мэндийн байгууллагатай дундын мэдээллийн сангаар 2570 хүүхдийн мэдээллийг солилцож ажиллав.	100%

					байна.		
2.3	Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх.	-	-Хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн тоо;	-	Иргэний улсын бүртгэлийн хил нэвтрэх үнэмлэх бүртгэл хөтлөгдсөн байна.	Хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх талаар ИУБГ-аас өгсөн чиглэлийн дагуу туршилт хийж, гарсан зөрчлийг тухай бүр илтгэх хуудсаар хүргүүлэн ажилласан. Өнөөдрийн байдлаар хүсэлт гаргасан 4 иргэнд хил нэвтрэх цагаан хуудас олгосон ба шинэ программаар хил нэвтрэх үнэмлэх цагаан хуудас олгоогүй болно.	100%
2.4	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	-	-Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо;  -Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	-Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийг хөгжүүлсэн, 5 удаа тестлэн алдааг засуулсан.  -Системийг ашиглах улсын бүртгэгч нарт зориулсан гарын авлага боловсруулсан.	Барьцааны гэрээ болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэсэн байна.	УБЕГ-ын даргын 2022 оны А/47 тоот тушаалаар цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд барьцааны гэрээ, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг 2022 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн батлагдсан шинэ маягт загварын дагуу бүртгэж эхэлсэн.УБЕГ-азрын 2022.09.13-ны 6/7670 тоот чиглэлд дурдсан ЭУБ-06, УБ-13 маягтын дагуу барьцааны гэрээг бүртгэж байна. Өнөөдрийн байдлаар Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэл 2263, Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл 1898 хөтлөгдсөн байна.	100%
2.5	Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл	-	-Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын мэдээлэл шалгах системд нийлүүлсэн мэдээллийн тоо;	2021 онд системд нэвтрэх эрх олгосон, “Нотариатчтай мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах” талаар Эд хөрөнгийн бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан	-Дундын мэдээллийн сангаар дамжуулан нотариатын нийлүүлсэн мэдээллийг тухай бүр шалгаж, бүртгэсэн байна.	Нотариатчтай “Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ”-г шинэчлэн байгуулах, дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх хийгдэж эхэлсэн талаар тус аймаг дахь нотариатчдад мэдэгдсэн ба манай аймгийн нотариатч нар зуучлах үйлчилгээ хийх талаар гэрээ хийгээгүй байна.	100%
			-Нотариатаар		-Нотариатчаар		

	нийлүүлэх, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд нотариатч зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.		зуучлуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн бүртгэлийн тоо.		зуучлуулан ЭХЭУБ хөтөлсөн байна.		
2.6	Газрын мэдээллийн болон хаягийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг Улсын бүртгэлийн мэдээллийн сантай холбох, эдгээр сангийн мэдээлэлд суурилсан хаягийн мэдээллийн сан үүсгэх, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах.	-	-Хаягийн мэдээллийн нэгдсэн сангаас арилгасан зөрчлийн тоо		-Орон нутаг дахь холбогдох байгууллагуудтай хамтран хаягийн мэдээллийн сан үүсгэх, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлсэн байна.	Аймгийн ИТХ-ын “баг байгуулах тухай” тогтоолын дагуу аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай хамтран, шинээр хуваагдсан багуудад эд хөрөнгийн хаяг өөрчлөгдсөн 399 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулан бүртгэсэн болно. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр Өлгий сумын хаягийн судалгааг гаргаж сумын Засаг даргад танилцуулсан ба Өлгий сумын ИТХ-аас гаргасан 2020 оны тогтоолыг албан бичгээр ИУБГ-т хүргүүлсэн болно.	100%
2.7	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	-Зөрчилтэй иргэн, хуулийн этгээдийн тоо  -Зөрчил арилсан тоо	2021 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 309 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг арилгасан байна.	Бүртгэлийн зөрчил арилсан байна	2022 онд мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 4899 иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн судалгааг бүртгэлийн төрөл тус бүрээр гаргаж зөрчил арилгах арга хэмжээ зохион байгуулсан. Иргэний улсын бүртгэлийн нийт 2744 иргэний зөрчилтэй мэдээллийг 1554 жагсаалтаар, 1030 иргэний мэдээллийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн арилгах арга хэмжээг авч	100%



					<p>хэрэгжүүлсэн.</p> <p>Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 7 хуулийн этгээдийн мэдээллийг ХУБ-д шилжүүлж, бүртгэлийн зөрчлийг арилгуулсан болно. ХЭУБГ-аас ирүүлсэн мэдээлэл нь зөрүүтэй 121 хуулийн этгээдийн мэдээллийг цахим сангаас шалган цахим санд зөвтгүүлэхээр хүргүүлсэн.</p> <p>Ургийн овог, эцэг, эхийн нэр, үндэс угсаа алдаатай, хаяг ороогүй, төлөв тодорхойгүй гэх зөрчилтэй иргэдийн өргөдөл хүсэлтийн дагуу дүгнэлтээр 460 иргэн, нэмэлт өөрчлөлтийн жагсаалтаар 1094 нийт 1554 иргэний зөрчлийг арилган ажиллав. ИУБГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 4/9698 тоот чиглэлийн дагуу Иргэний улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ирсэн чиглэлийн дагуу ХУБ-ийн дүгнэлтээр өнөөдрийн байдлаар 63 иргэний мэдээлэлд өөрчлөлт оруулсан. 2022.11.02 өдрийн 4/9443 тоот чиглэлийн дагуу сумдад баталгаажуулалтыг хийж эхэлсэн байгаа.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цаасан суурьт баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг нэвтрүүлэх явцад мэдээллийн санд зөрүүтэй, алдаатай оруулсан эсэх, мөн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, зөрчил арилгах зорилгоор сар бүр хуваарь гарган хэлтсийн даргаар батлуулан /1 улсын бүртгэгч сар бүр 100 бүртгэл/ 5000 бүртгэлийг мэдээллийн сантай тулгалт хийн шалгаж, мэдээллийн санд зөрүүтэй, алдаатай гэх 521 бүртгэлийн зөрчлийг арилган ажиллав. УБЕГ-ын</p>	
--	--	--	--	--	--	--

						ЭХЭУБ-аас ирүүлсэн 2022.11.08-ны өдрийн 6/9582 тоот хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд нийт 389 зөрчлийг мэдээллийн сантай тулгаж, зөрчлийг арилгаж ажиллав.	
2.8	Сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлэх.	-	-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын тоо;  -Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоо.	Эрх зүйч мэргэжилтэй 8 албан хаагчийн судалгааг гаргаж хүргүүлсэн, 2021 тусгай хөтөлбөрт сургалтанд 8 сумын улсын бүртгэгч хамрагдсан ба шалгалтанд тэнцсэн. Дэлүүн сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн эрх авч, улсын бүртгэл хөтөлж эхэлсэн.	-Сумдад бүртгэх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.	Тус аймгийн 5 суманд эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байна. Өнөөдрийн байдлаар Дэлүүн сумын улсын бүртгэгч С.Рысбай 221, Алтанцөгц сумын улсын бүртгэгч А.Бадамсүрэн 39, Улаанхус сумын улсын бүртгэгч Б.Бахитгүл 91, Алтай сумын улсын бүртгэгч Болормаа 13, Цагааннуур тосгонд Айсауле 31 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.	100%
2.9	Улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа, хуулбар олгох	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон лавлагаа, хуулбарын тоо;  -Эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэл хийсэн бүртгэлийн тоо;	-2021 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас нийт лавлагаа 8134 олгосноос албан хэрэгцээнд 870, хууль хяналтын байгууллагаад албан тоотоор 528, иргэнд 6736 лавлагаа, 712 хуулбар  -хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, хууль хяналтын байгууллагад 89	Улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа, хуулбар, нотлох баримтыг иргэн, хуулийн этгээд, хууль, хяналтын байгууллагад хуулийн хугацаанд олгосон байна.	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 9349 лавлагаа олгосон ба иргэнд 7176 лавлагаа, албан хэрэгцээнд 707 лавлагаа, хууль хяналтын байгууллагад албан тоотоор 1466 лавлагааг тус тус олгож ажиллав.  Хуулийн этгээдийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдэд 71 лавлагаа, 69 хуулбар гаргаж өгсөн. Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 97 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд гарган өгч, ирсэн албан бичгийн дагуу 82 лавлагаа, 4 хуулийн этгээдийн бүрдүүлбэрийн хуулбарыг гаргаж өгсөн болно.  Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийн дагуу 727 лавлагаа, хуулбар	100%

				<p>хуулийн этгээдийн лавлагаа, 167 хуулбар</p> <p>- эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хууль хяналтын байгууллагад 191 лавлагаа, хуулбар, иргэн, хуулийн этгээдэд 59 лавлагаа, 75 хуулбар олгосон ба 10 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, эрх бүхий шийдвэр, хүсэлтийг хувийн хэрэгт хавсаргаж цахимжуулсан болно</p>		<p>олгосон байна. Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 315 лавлагаа мэдээллийг албан тоотор хүргүүлэн ажиллаж, 85 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, 25 эрх улсын бүртгэлийн эрхийн түдгэлзүүлэн, 23 эрхийн улсын бүртгэлийн эрхийг сэргээж эрх бүхий этгээдийн шийдвэр, хүсэлтийг хувийн хэрэгт нь хавсаргаж цахимжуулсан болно.</p>	
2.10	Улсын бүртгэлийн хэлтэст хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах.	-	Цахимжуулсан эх нотлох баримтын тоо	Иргэний улсын бүртгэлийн онлайн, офлайн системийн хөгжүүлэлтээр иргэний улсын бүртгэл хөтөлсөн эх нотлох баримт бичгийг цахимжуулах боломжийг бүрдүүлж, тоног төхөөрөмжөөр хангасан.	2022 онд хөтөлсөн ИУБ-ийг бүрэн цахимжуулсан байна.	Иргэний бүртгэлийн баримтыг 2022 оны 1 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн цахимжуулах ажлыг эхлүүлсэн ба эхний 11 сарын байдлаар 12061 бүртгэлийн 32610 хуудас материалыг цахимжуулсан болно.	100%

2.11	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	<p>-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх;</p> <p>-Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;</p>	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	<p>Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл авах эрх бүхийн байгууллага бүхий Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, болон бусад Хууль хяналтын байгууллагын хүсэлтийн дагуу тогтмол мэдээ, тайлан мэдээлэл хүргэн ажиллаж байна. Мөн орон нутаг дахь салбар зөвлөлийн гишүүнээр ажиллаж аливаа хурал зөвлөгөөнд оролцон ажиллаж байна. Тайлагнасан ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн захиргааны албан хаагчийн 2021 оны ХАСХОМ-ын нэгдсэн тайлан,</li> <li>- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт</li> <li>- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2022 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт</li> <li>- Хүний эрх, хүн худалдаалахтай тэмцэх</li> <li>- Терроризмоос урьдчилан сэргийлэх</li> <li>- Жендэрийн тэгш байдлыг хангах ажлын төлөвлөгөөний биелэлт</li> <li>- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх</li> <li>- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх</li> <li>- Аймгийн Засаг даргын 01 тоот үүрэг даалгаврын биелэлт Монгол бичгийн тайлан</li> <li>- Мэдээллийн ил тод байдлын тайлан</li> <li>- Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээ</li> <li>- Гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягтын сар бүрийн зарцуулалтын тайлан</li> </ul>	100%
------	--	---	--	--	---	--	------

						<ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн гүйцэтгэл, үйлчилгээний орлогын тайлан</li> <li>- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээг УБЕГ-т хүргүүлж ба хэлтсийн цахим хуудасны тоон мэдээ цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.</li> </ul> <p>УБЕГазрын газар, хэлтсүүдэд хугацаат тайлангийн биелэлтүүдийг цаг тухайд нь хүргүүлэн ажиллаж байна.</p>	
2.12	Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын баримтын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх зорилтыг	-	Нэгдсэн тоо бүртгэлийн тоо		Нэгдсэн тоо бүртгэл хөтлөх.	<p>Хуулийн этгээдийн архивын хувийн хэргийн тоог цахим мэдээллийн сантай тухай бүр тулган, шалгаж нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөн ажиллаж байна.Хуулийн этгээдийн нийт хувийн хэргийн тоо 2400, эд хөрөнгө 33516 хувийн хэрэг байна.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 33516 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнээс 15521 газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 13398 газар өмчлөх эрхийн бүртгэл, 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг 6 байна.</p> <p>Иргэний бичиг баримтын архивт одоогийн байдлаар нийт 169,993 хувийн хэрэг хадгалагдаж байна. 2022 оны 12 сарын 01-ний байдлаар 2720 маягт нэмэгдсэн байна.</p>	100%
<b>Зорилт 3. Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</b>							
3.1	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих.	-	-Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2021 онд нэгжийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын мөрөөр	-Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулсан	Тус хэлтсийн 2022 онд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай төлөвлөгөө гаргаж, батлуулан төлөвлөгөөний дагуу 5 удаа, 6801 бүртгэлд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, ерөнхий байцаагчийн	100%

				авч хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах талаар улсын байцаагчийн 15 албан шаардлага, 2 мэдэгдэл, 2 актыг хүргүүлж ажилласан.	байна. -Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шалгалт хийсэн байна.	хяналт шалгалт хийх тухай удирдамж, Хяналт шалгалтын газраас ирүүлсэн үүрэг чиглэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, Иргэний улсын бүртгэлийн газар, Архивын газраас тус тус ирүүлсэн чиглэлийн дагуу 2022 онд бүртгэгдсэн нийт 26120 улсын бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 5, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 6, гүйцэтгэлийн хяналт шалгалт 2 удаа хийж, илрүүлсэн зөрчилд тэмдэглэл үйлдэж зөрчил арилгах тухай 16 албан шаардлагыг холбогдох тус хэлтсийн төвийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, архивч, 13 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт хүргүүлэн зөрчил арилгуулах арга хэжээ авч ажилласан байна. Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 24 хуулийн этгээдийн мэдээллийг Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгуулсан болно. Мөн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл гомдолын мөрөөр нийт 1903 иргэн, хуулийн этгээдийн холбогдох бүртгэлд тухай бүр хяналт шалгалт хийж нийт 257 дүгнэлт, 16 албан шаардлага, 30 акт үйлдсэн байна. байна.	
3.2	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх.	-	-Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн тоо;  -Зөрчлийг зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэсэн тоо.	<b>5</b> хуулийн этгээд, <b>260</b> хүний зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж <b>7.490.000</b> төгрөгийн торгуулийг оногдуулсан. Иргэн, Хуулийн этгээдийн зөрчлийн талаарх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчил шалган шийдвэрлэсэн хэрэг, материалыг хуульд заасан хугацаанд /нэн даруй/ холбогдох прокурорт	2022 онд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчил нийт 5 хуулийн этгээд, 187 хүний зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 6665000 төгрөгийн торгуулийг оногдуулсан. Иргэн, Хуулийн этгээдийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, үйлдсэн зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлсэн 3, Иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан 19, хэрэгсэхгүй болгосон. Мөн	100%

				гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, үйлдсэн зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлсэн 2, Иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан 39, хэрэгсэхгүй болгосон. Мөн 2 Иргэнд зөрчилд зөрчлийн хэрэг нээж шалган шийдвэрлэсэн.	хянуулан, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.	2 Иргэнд зөрчилд зөрчлийн хэрэг нээж, шалган шийдвэрлэсэн байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д харьяалуулсан нийт 192 зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна, тухай бүр материалыг прокурорт хүргүүлэн хянуулан, мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Прокурорын газраас ирүүлсэн үүрэг даалгавар, заавар, мэргэжил арга зүйн удирдлагаар хангуулан улирал сар бүр шалгуулан ажиллаж байна. 2022 онд Зөрчил шалган шийдвэрлэх материалыг эх хувиар Прокурорын газарт хоёр удаа хүргүүлэн, мөн зөрчлийн материалыг тухай бүрд шалгуулан хянуулж зохих хууль журмын дагуу ажиллаж байна.	
3.3	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	2021 онд зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд 12 арга хэмжээ төлөвлөн, 100 хувь биелүүлсэн.	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2022 онд зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд 12 арга хэмжээ төлөвлөн, 12 арга хэмжээг цаг тухай бүр бүрэн 100 хувь биелүүлсэн. Мөн Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байнга иргэн хуулийн этгээдэд улсын бүртгэлийн хууль тогтоомж, ач холбогдлын талаар мэдээллийг олон нийтэд байнга танилцуулж, мэдээлэл өгч, сургалт зохион байгуулан иргэн, хуулийн этгээдийн мэдэх эрхээр нь ханган зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. Гэмт хэрэг, Зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль хяналтын байгууллагатай нягт хамтран ажиллаж байна.	100%

3.4	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2021 онд төлөвлөгөөт 15 хяналт шалгалт хийж, 9 дүгнэлт гаргасан.	Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2022 онд Хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.Үүнд: төлөвлөгөөт 11 хяналт шалгалт, 6 гүйцэтгэлийн шалгалт, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 19 удаа 6476 хөтөлсөн бүртгэлд шалгалт хийж, 15 дүгнэлт, иргэний өргөдөл, санал гомдлын мөрөөр 612 бүртгэлд хяналт шалгалт хийж бүртгэлийн зөрчил арилгах, нэмэлт өөрчлөлт оруулах хүчингүй болгох зэрэг 136 дүгнэлт үйлдэж нийт 1829 бүртгэлд нэмэлт өөрчлөлт, мөн Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 4899 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, зохих өөрчлөлтийг тусгаж, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр 1380 улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн бүртгэлийг хянаж шалгаад 131 дүгнэлт, 5 албан шаардлага гарган хүргүүлэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	100%
3.5	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь.	2021 оны жилийн эцсийн байдлаар нэгжийн шилэн дансны мэдээлэл байршуулалт 100 хувь дүгнэгдсэн.	-Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, байршуулах ёстой мэдээллийг хугацаандаа үнэн зөв, бүрэн байршуулсан байна;  -Байршуулсан мэдээллийг хуулийн хугацаа, үнэн, зөв байршуулсан эсэхэд сар бүр	Эхний 11 сарын байдлаар оруулах ёстой шилэн дансны тухай бүр оруулах 88, сар бүр оруулах 33, улирал бүр оруулах 3, хагас жилийн туршид оруулах 3, бүтэн жилийн туршид оруулах 5 мэдээллийг цаг хугацаанд байршуулсан болно.	100%



					<p>хяналт тавьж ажилласан байна;</p> <p>-Тайланг улирал тутам, хугацаанд нь УБЕГ-т хүргүүлсэн байна.</p>		
3.6	Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, цахим хуудаст байршуулах, тайлан гаргах.		Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнаж ажилласан.		<p>-Санхүүгийн тайланд тусгасан байна;</p> <p>-Худалдан авах ажиллагааны тайланг дээд газарт хүргүүлсэн байна.</p>	Тайлант онд ямар нэгэн худалдан авалт хийгдээгүй. Батлагдсан төсвийн хүрээн дэх төсвийн зарцуулалтыг шилэн дансаар тогтмол хуулийн хугацаанд тайлагнан ажиллаж байна.	100%
3.7	Хэлтсийн төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах.	Урсгал төсөв /467.50 5 сая төгрөг/	Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	2021 онд 524.751.900 төгрөгийн урсгал төсвөөс 524.258.483 төгрөгийг зарцуулсан.	<p>-Санхүү, төсвийн удирдлага, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон тайланг хуульд заасан хугацаанд нь дээд газарт хүргүүлсэн байна;</p> <p>-Санхүүгийн тайланг аудитын байгууллагаар хянуулсан байна;</p> <p>-Санхүүгийн сахилга, батыг хангах, өр төлбөр, зөрчилгүй ажилласан байна.</p>	2022 оны 4 дүгээр улирлын байдлаар улсын төсвөөс 477.877.5 мян төгрөгийн санхүүжилт авснаас 473.866.642 төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, 4.010.858 төгрөгийн хэмнэж, тайлагнаж, холбогдох мэдээллийг байршуулан ажиллав.	100%

3.8	Хэлтсийн архивын санг зориулалтын нягтруулсан шүүгээгээр шинэчилж сайжруулах.	Төсөл хөтөлбөр Улсын бүртгэлийн ерөнхий газар		Одоо ашиглагдаж байгаа шүүгээ зориулалтын бус, ашиглалтын шаардлага хангахгүй.	-Архивын байрны тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.	Орон нутгийн удирдлагуудад удаа дараа хүсэлт хүргүүлж, Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 11 дэх удаагийн чуулганд саналаа оруулж хэлэлцүүлэн архивын байранд зориулалтын нягтруулсан шүүгээний 10.000.000 сая төгрөгийг шийдвэрлүүлж ажиллав.	100%
3.9	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандарт, архивт орчин үеийн хяналтын камер байршуулах тоо, ширхэг	Байгууллагын төрийн онцгой нууцын зэрэгт хамрагдах архивын хадгаламжийн нэгжийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хянах хүчин чадал бүхий хяналтын камер байршуулахад дэмжлэг үзүүлэх.	Орчны аюулгүй байдлыг хянах, иргэдийн төрийн үйлчилгээ авах хяналт сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 4.800.000 төгрөгийн нийт камер – 12, үүнээс 4 ширхгийг архивд, 8 ажлын өрөөнүүдэд орчин үеийн хяналтын ip камер байршуулсан. Мөн түрээслэгч байгууллагатай гэрээ хийж, архивын нэмэлт өрөө гаргуулж нөхцөл байдлыг сайжруулж ажиллаж байна.	100%
3.10	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо; -Шүүх хуралдаанд оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл;	Хууль, хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажилласан.	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд хууль тогтоомжийн дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон байна.	Иргэн, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр эхний улирлын байдлаар хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцоогүй болно. Хуулийн этгээдийн чиглэлээр шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа 2 хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон оролцож 3 удаагийн шүүхэд оролцсон болно. Рахман мешит Шашны байгууллагатай холбоотой хэрэг маргаанд Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр холбогдох бүртгэл хүчингүй болсон боловч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны үндсэн дээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулсан болно. Улсын бүртгэлийн	100%

						<p>Ерөнхий газрын даргын А/1297 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагад шийдвэрлэгдэж буй байгаа, хэрэг, маргааны явцад хяналт тавих журмын дагуу Хяналтын улсын байцаагч 2020, 2021, 2022 оны шийдвэрлэгдсэн болон маргааны явцын талаар шүүхээс шийдвэрүүдийг татан авч бүрдүүлэн Хяналт шалгалтын цахим санд 2020 онд 4, 2021 онд 2, 2022 онд 3 захиргааны хэрэг маргааны холбогдох мэдээлэл, шүүхийн шийдвэрүүдийг цахимжуулж мэдээллийг тухай бүр шинэчилэн хөтлөж байна. 2022 онд хууль, хяналт, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулаагүй, хариуцагчаар албан хаагчийн шууд нэр заагдсан байх тул итгэмжлэл боловсруулсан, баталуулсан одоогоор гараагүй байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--

Зорилт 4. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар орон нутгийн удирдлагуудтай, төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллана.

4.1	<p>Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах</p>	-	<p>Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх; Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах;</p>	<p>2021 онд тус аймгийн 13 сум, 1 тосгоны мэдээллийн самбарыг нэг стандартад нийцүүлэн бүрэн шинэчилж байршуулсан.</p>	<p>Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.</p>	<p>Аймгийн удирдах ажилтаны шуурхай хурал тогтмол оролцож байгаа. Бусад байгууллагуудын упирдлагуудтай 4 удаагийн уулзалт зохион байгуулсан.</p> <p>Засаг даргын нөөц хөрөнгөнөөс орон нутагт томилогдон ажиллаж байгаа албан хаагчийн амьдрах байрны түрээсийн зардал шийдүүлсэн.</p> <p>Аймгийн ИТХ, Засаг даргад тус хэлтэст тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал хүргүүлж, хэлтсийн байранд орчин үеийн чанарын шаардлага хангасан 4.800.000 төгрөгний хяналтын камер болон архивын байранд зориулалтын</p>	100%
-----	---	---	---	--	--	--	------

						<p>нягтруулсан шүүгээний 10.000.000 төгрөг, орон нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажилагааг бэхжүүлэх зорилгоор нууцын зэргэлэлийн баримт бичиг хадгалах сейф 1.550.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн. Өлгий, Цэнгэл сумуудад Улсын бүртгэлийн КИОСК машин худалдаж авахаар Засаг дарга нартай УБХ-ийн дарга, Улсын бүртгэгч нарын хамтран байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан ажлаа бүрэн хэрэгжүүлж тус бүр 23.000.000 /хорин гурван сая/ төгрөгийн үнэ бүхий өртөгтэй Улсын бүртгэлийн КИОСК машин худалдан авсан. Эхний ээлжинд Өлгий сумын КИОСК машиныг “Нью компас” ХХК-ны захирал Р.Мөнхбаттай бүтээгдэхүүн нийлүүлэлт, суурилуултын гэрээ байгуулан ажиллуулж эхэллээ.</p>	
4.2	Сумдын удирдлагатай хамтын ажиллагаагаа сайжруулах	-	Сумдаас архивын цаасан эх нотлох баримтыг баталгаат шуудангаар татан авахад дэмжлэг авах;	Бүх сумдын улсын бүртгэгч нарын мэдээ мэдээллийн самбарыг шинэчилж нэг стандарттай болгосон.	Сумдын удирдлагуудтай хамтын ажиллагаа сайжирсан байна.	<p>Пос машин авах хөрөнгө мөнгө шийдвэрлүүлэх талаар аймаг, сумдын удирдлагуудад танилцуулан, хүсэлт тавьж ажиллаж байна. Орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах хүрээнд Дэлүүн, Улаанхус сумын улсын бүртгэгч нар сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Гэрэгэ Киоск цахим төлбөрийн машины болох тус бүр 7,000,000 /долоон сая/ төгрөг шийдвэрлүүлэн, Ногооннуур сум 3,000,000 /гурван сая/ үлдсэн төлбөрийг дараа онд шийдвэрлүүлэхээр Гэрэгэ системс компанитай гэрээ байгуулан суурилуулахаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн төвийн Өлгий суманд сүүлийн 2 жил пос машинаар үйлчилгээ үзүүлж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй 5 сумаас архивын</p>	100%

					цаасан эх нотлох баримтыг баталгаат шуудангаар татан авах талаар сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллаж архивын эх нотлох баримтыг баталгаат шуудангаар татан авч байна.  Мөн тухайн 5 сумдын улсын бүртгэгчдийг тусдаа өрөөнд суух асуудлыг шийдвэрлүүлсэн.		
4.3	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах	-	-Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл;  -Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо;	Орон нутгийн "Саян", "Дербес" телевизээр 2 удаа, орон нутгийн радиод 8 удаа ярилцлага өгч иргэд олон нийтэд хууль тогтоомж болон ажлын үзүүлэлтийн талаар мэдээ, мэдээлэл хүргэж ажиллав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа, цахим хуудсаар 6 удаа Аймгийн Засаг даргын тамгын газраас санаачлан хэрэгжүүлсэн төрийн үйлчилгээний "ХӨДӨЛГӨӨНТ БАЙР" төрийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь түргэн шуурхай хүргэх удирдамжийн дагуу 13 сумдад ажиллаж 230 эд хөрөнгийн	Улсын бүртгэлийн хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилж, иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тогмтол ярилцлага өгч, албан байгууллагуудад мэдээллийн цаг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, сумдын улсын бүртгэгч нар БИНХ-д оролцож мэдээлэл өгч ажиллаж байна.  Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нутгийн төрийн захиргааны байгууллагын хууль тогтоомжийг Орон нутгийн Саян, Дербес телевиз, олон нийтийн радиогоор сурталчлах баталсан график төлөвөлгөөний дагуу иргэдэд мэдээ мэдээлэл 12 удаа ярилцлага өгсөн болно.	100%

				бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, иргэдэд тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэсэн байна.			
<b>Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.</b>							
5.1	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх.  /Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах/	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо;	Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулсан.	-Хэлтсийн 2022 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, баталсан байна;  -Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудад хуваарийн дагуу албан хаагчдыг хамруулсан байна;	Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн албаны зөвлөл, Бусад хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 55 удаагийн сургалтад давтагдсан байдлаар 884 албан хаагч хамрагдсан байна. Хэлтсийн 2022 оны сургалтын төлөвлөгөө боловсруулж, баталуулан, төлөвлөгөөний дагуу улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурталчилах зорилгоор нийт 12 сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд 7 дотоодтой, 5 бусад байгууллага, албан тушаалтан нартай хамтран зохион байгуулав.	100%
5.2	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд 2021 онд хэлтсийн 6 албан хаагчийг хамруулсан байна.	Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах чиглэлээр тодорхой дэмжлэг авч, үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажилласан байна.	Ерөнхий газраас авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт албан хаагчдаа хамруулах санал хүсэлт хүргүүлэн дэмжин ажиллаж байна. Цалинтай холбоотой зэрэг дэв ахиулах санал хүсэлтийг хүргүүлэн хуулийн хугацаанд хамруулан ажиллаж байна. Гэрээт 3 албан хаагчийн цалин шинэчлэгдсэнтэй холбоотой цалингийн нэмэгдэлээр олгож эхэлсэн. Дотоод журамд заасны дагуу шинээр төрсөн хүүхэдтэй болсон 3 албан хаагчид нэг удаагийн тэтгэмж 100.000	100%

					<p>төгрөг нийт 300.000 төгрөг, мөн шинээр гэр бүл болсон нэг албан хаагчид 400.000 төгрөгний нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэн ажилласан. 2 албан хаагчийн цалинтай чөлөө хүссэн тухай өргөдлийг УБЕГазарт уламжлан шийдвэрлүүлсэн. Ажлын байрны дарамт стресс, жэндерийн хайрцаг тогтмол авч ажиллаж байна.</p>
--	--	--	--	--	---

Төлөвлөгөөг хянасан:

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../Д.ДЭЛГЭРСАЙХАН/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....  
(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан: :

**Төсвийн Шууд захирагч**

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ...../Х.АМАНГҮЛ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

2022.12.05  
(огноо)

